

Эдийн засгийн
хамтын
ажиллагаа

**Зүүн Хойт Азийн бүс нутгийн орнуудын
эдийн засгийн хамтын ажиллагаа,
Монголын оролцоо.**

Доктор, профессор Х.Дашдондов

Хүн төрөлхтөний хөгжил дэвшилд ХХ зуун бүхэлдээ хувьсал өөрчлөлтийн эрин зуун байсны дотор сүүлийн арваад жилд эрс хувьсалт өөрчлөлтөөр улс орнууд дэлхийн нийтийн жам ёсны хөгжил дэвшилд шилжих үйл явц эрчимтэй өрнөсөн билээ.

Дэлхий дахинаа хоёр системийн тэмцэл, “Хүйтэн дайн” төгсгөл болж, бие биений эсрэг сөрсөн хоёр туйлт харилцаанаас олон туйлт харилцаанд шилжиж байна. Энэ бол хүн төрөлхтөний хөгжил дэвшилд гарсан асар том хувьсал мөн.

Гуравхан жилийн дараа эхлэх шинэ эринд нэгдмэл хөгжлийн хамгийн түгээмэл хууль, зүй тогтол, дэлхийн хөгжлийн ерөнхий хандлага болон бүс нутаг, улс орон бүрийн хөгжилд бодитой үйлчилж эхлэх гэж байна. Шинжлэх Ухаан-Технологийн /ШУТ/ хувьсгал улам эрчимжиж, үр дүн нь хүн төрөлхтөний жам ёсны нэгдэлт хөгжилд нийтлэг хэлбэрээр нэвтрэх нь хөгжлийн хурдцыг эрс түргэтгэх боломжтой болгож өгөв.

Энэ нь юуны өмнө урьдын адил зөвхөн тухайн системийн буюу өөрийн орны ололтод тулгуурласан ШУТ-гийн бааз дээр хөгжих биш, харин аль ч оронд өөрийнх нь давуу талт /байгалийн баялаг, хүний хүчин зүйл-оюуны чадавхи, техник, технологи г.м./ ямар боломж байна, түүнийгээ гадаад харилцаа, хамтын ажиллагаанд идэвхтэй ашиглах замаар, тэрхүү өөртөө байгаа давуу талыг эрчимтэй ашиглаж техник, технологи, ажиллах хүч, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрээ улам аривжуулах эдийн засгийн нөхцөлтэй болж байна. Эдийн засгийн ийм нээлттэй ертөнцөд ямар ч улс зөвхөн өөрийн хүч хөрөнгөөр бие даан хөгжих бололцоогүй болжээ гэдэг нь тодорхой. Түүхэн зайлшгүй ийм үйл явдлаас үүдэн улс хоорондын харилцаа, хамтын ажиллагаа олон хэлбэрийг агуулж байгаагийн дотроос тив ба бүс нутгийн хамтын ажиллагаа бүр ч ач холбогдолтой. Дэлхийн нэрт эдийн засагч-эрдэмтдээс ХХI зууныг урьдчилан таамаглаж буй прогнозоор үзэхэд тивээр зааглан хөгжих таамаглал ч бий.

Манай дэлхий ирээдүйд хэт их гүрэнгүй Европ, Америк, Ази гэсэн гурван том туйлд хуваагдаж магадгүй гэдэг ч томъёолол бий. Энэ нь дараах байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

1. Европ нэгдэх хандлага одоо улам бодиттой болж байна. Европын эдийн засгийн нийтийн зах зээл байгуулж, нэгэн ижил мөнгөн тэмдэгтэй болох гэж байна.

2. Америк тивийн худалдаа, хөгжилд нааштай эхлэл тавигдаж, АНУ, Канад, Мексикийн хооронд чөлөөт худалдааны бүс байгуулах эхлэл тавигдлаа.

3. Азид ч ийм хандлага газар авч энэ чиглэлээр Ази Номхон далайн эдийн засгийн зөвлөл идэвхтэй ажиллаж байна. Энэ бүс нутагт Япон, Азийн “бар”-ууд, тэдгээрийг тойрон хүрээлсэн бүс нутгийн бүлэглэлүүд үүсэх төлөв бий. АСЕАН-ы орнууд болон Азийн “ бар”-ууд эдийн засгийн 6 хувийн өсөлттэйгээр хөгжиж, дэлхийн өндөр хөгжил бүхий нэгэн бүс нутаг болж байна. Азийн хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжлийн өндөр хурдац хэвээрээ үргэлжилсээр байна.

Харин одоохондоо Европтой зэрэгцүүлэхэд Ази Номхон далайн бүс нутагт хамтын ажиллагааны процесс харьцангуй удаавтар явж байгаад дүгнэлт хийж, тус бүс нутгийн эрдэмтэд бид баяртай оролцож байна.

Гэвч энэ бүс нутагт хамтын ажиллагааны асар их туршлага хуримтлагдсаныг тэмдэглэх нь зүйтэй. Үүнд: Өмнөд Азийн орнуудын хүрээнд СААРК, Зүүн өмнөд Азийн орнуудын хүрээнд хамтын ажиллагааны олон талын судалгаа шинжилгээ, яриа хэлэлцээ, удирдан чиглүүлэх ажил эхлэлтийнхээ шатанд явж байгааг түргэтгэх шаардлага зүй ёсоор дэвшигдэж байгаа юм. Энэ бүс нутаг хамтран ажиллаж амжилтанд хүрэх бүх талын боломж бий. Тухайлбал, энд дэлхийн эдийн засагт техник технологийн тэргүүний хөгжилтэй орнуудын нэгэнд ордог Япон улс бүс нутгаа хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж байна. Бас хөгжлийн түвшингээр Азид төдийгүй, дэлхийд дээгүүр ордог, зарим үзүүлэлтээрээ тэргүүлдэг БНСУ, Тайвань, Сингапур болон АСЕАН-ы орнуудын эдийн засгийн өсөлт, хурдац нь Ази Номхон далайн бүс нутгийн хөгжлийн эрчимжилтийг баталгаажуулж байна.

Тэгээд ч энэ бүс нутагт АНУ-ын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны үйл явц улам бүр өсөж байгаа нь тус бүс нутгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх найдвартай

баталгаа болж байна. Тус нутгийг эрчимтэй хөгжүүлэх байгалийн ашиглагдаагүй асар их нөөц баялаг, түүнийг ашиглах орчин үеийн техник, технологийн “давуу тал”-д түшиглэн түргэн хөгжих боломжтой.

Зүүн Хойд Азийн салбар бүсэд БНХАУ-ын Зүүн хойд Хэсэг, ОХУ-ын Алс Дорнод, Монгол Улсын дорнод хэсэг, БНАСАУ, БНСУ, Японыг хамруулан авч үздэг юм.

Одоо Зүүн Хойд Ази /ЗХА/ бол Ази тивийн нутаг дэвсгэрийн 20%, хүн амын 10% буюу 300 сая хүн амьдардаг, нийгмийн нийт бүтээгдэхүүний 70%-ийг эзэлж байна. Энэ бүс нутагт Орос, Хятад, Монгол, Хойт Солонгосын байгалийн ба хөдөлмөрийн нөөцийг Япон, Өмнөд Солонгосын үйлдвэрлэлийн өндөр чадавхи, тэргүүний технологитой хослуулан хөгжүүлэх замаар бүсийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, улмаар эндхийн орнуудын хувьд эдийн засгийн талаар бие биеэ нөхөн эрчимтэй хөгжих бодит бололцоо бүрэн бий гэж үздэг юм. Тухайлбал:

-Япон, Өмнөд Солонгос зэрэг улс санхүүгийн нөөц, тэргүүний технологи, тоног төхөөрөмж, удирдлагын туршлагаар дээгүүр ордог, харин түүхий эд ба хөдөлмөрийн нөөцөөр дутмаг,

-ОХУ-ын Алс Дорнодын хувьд ой мод, өнгөт металл, төмөрлөгийн орд, газрын тос, шатдаг хий, нүүрс, хүнд болон химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой ч хөдөлмөр, санхүүгийн нөөцөөр дутмаг, тоног төхөөрөмж, удирдлагын систем нь хангалттай төгөлдөржиж хараахан амжаагүй,

-БНХАУ-ын зүүн хойт хэсэгт хөдөө аж ахуй хөгжүүлэх тааламжтай нөхцөлтэй, нэхмэлийн үйлдвэрийн зарим бүтээгдэхүүн, нефть, нүүрс, барилгын материал, эмийн ургамал, хөдөлмөрийн нөөцөөр хангалттай, харин хөрөнгийн эх үүсвэр, тэргүүний технологи, удирдлагын туршлага, байгалийн зарим эрдэс, дэд бүтцийн хувьд дутагдалтай.

Хойд Солонгосын хувьд мөн л байгалийн эрдэс, төмрийн хүдэр, аж үйлдвэрийн зарим бүтээгдэхүүн хөдөлмөрийн нөөц хангалттай, харин хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай.

Монгол улс ХАА-н үйлдвэрлэл хөгжүүлэх бололцоотой, дорно хэсэгт нь хүдэр, хайлуур жонш, нүүрс, нефть холимог төмөрлөгийн ихээхэн нөөцтэй, харин Зүүн хойт Азийн

орнуудтай холбосон зам харилцаа муу хөгжсөн, хөрөнгө, технологи дутмаг.

Энэ байдалд үндэслэн үзвэл эл бүсийн орнуудын эдийн засаг бие биеэ нөхөн хоршин хөгжих бололцоо нөхцөл бүрэн бий гэж эдийн засагчид, эрдэмтэд үздэг.

Монгол улс Зүүн Хойд Азийн бүсэд өөрийн сул талаа нөхөж, харьцангуй давуу талаа ашиглах, хамтын ажиллагааны эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийг түргэтгэх өргөн боломжтой болох юм. Гадаад талын нээлттэй регионализмийн ийм орчинг хир зохистой ашиглаж, идэвхи үйл ажиллагаа явуулахаас манай орны хөгжлийн ирээдүй шалтгаална.

Одоо үед дэлхийн эдийн засаг гол татагдах тэнхлэг болох өндөр хөгжилтэй орнуудаа түшиглэсэн бүс нутгуудад хуваагдах ерөнхий хандлага улам гүнзгийрч, бүсүүд дотроо “хөгжлийн гурвалжин” гэж нэрлэгдэх бүсүүдэд хуваагдаж эхэллээ.

Монгол Улс “хөгжлийн гурвалжин”-гийн регионализмын хувьд Зүүн Хойд Азийн бүс нутгийн хамгийн гол нутаг нь болох юм. Учир нь манай улсын нутаг нь Төв Азийг Ази, Европтой, мөн Зүүн Өмнөд, Өмнөд Азийг Оросын Сибиртэй холбоход газарзүйн таатай байршилд оршдог. Монгол нутаг бол Төв Азийн Зүүн Хойт хэсэгт Сибирийн ой тайга, Төв Азийн цөлийн бүсийн зааг дээр оршдог болохоор Сибирийн ой тайгын бүсийн өмнөт хил Монголын Умарт хэсгийн зарим газраар 130-200 км, Төв Азийн цөлийн умарт хил Монголын өмнөт хэсгээр 1600 гаруй км өргөн газраар 50 300 орчим км гүн цөмрөн орсон байршилтай байдаг. Тэгээд ч Европ тивийн Мажарын дунайн нүшгийн нам дор газраас Ази тивийн Хятадын Манжуурыг хүртэл үргэлжлэх хээрийн бүс Монголын нутаг дэвсгэрийн дунд хавиар Өрнөөс Дорныг хүртэл нэвт үргэлжилдэг учир Монгол нутаг Европ, азийг холбох орон зайн нөхцөл бүрдсэн, Зүүн Хойт Азийн бүсийн дэд бүтцийг хөгжүүлэхэд нэн тааламжтай байршилтай зэрэг олон талын ашигтай юм. Зүүн Хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд чухал байр суурь эзлэх үйлдвэрлэлийн дэд бүтцийн шинэ сүлжээ бол ОХУ-ын Сибирээс Монголын нутгийг дайруулан Хятад, Өмнөд Солонгос, Япон хүрэх олон улсын нефть, шатдаг хий дамжуулах хоолой шугам барих ажил ч байж болох юм гэж эрдэмтэд тооцдог. Бас үүнийг баруун тийш нь тэлж Европын орнуудтай ч холбож болох юм. Хэрэв

тэгвэл XXI зууны Ази Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагаанд нилээд чухал нөлөө үзүүлж болох төлөвтэй байна.

Түмэн голын эдийн засгийн хөгжлийн бүсийн үйл ажиллагаанд Монгол Улс идэвхитэй оролцох явдал зөвхөн газар зүйн төдийгүй, бас эдийн засгийн бодитой шаардлагаас зайлшгүй юм.

Тэгэхээр Монгол-Зүүн Хойт Азийн орнуудын харилцан ашигтай хамтран ажиллах боломж, зарим онцлогуудыг авч үзье. Үүнд:

Монгол Улс, Зүүн Азийн орнуудын хооронд эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах хэлэлцээр сүүлийн жилүүдэд байгуулагдсан явдал бол Азийн орнууд харилцан ашигтай хамтран ажиллах, хөгжлийнхээ хурдцыг түргэтгэх, Азийн гэгдэх XXI зууны бүс нутгийн интеграцийн хуваарьт баттай суурь эзлэх бэлтгэлийг хангахад онцгой ач холбогдолтой болж байна. Ер нь сүүлийн жилүүдэд Зүүн Хойт Азийн орнуудын эдийн засаг, ШУТ-ийн байгууллага, пүүс, хүмүүсийн хоорондын хамтын ажиллагааны чиглэлээр нилээд ажил шуурхай явагдаж тэр нь ард түмний дэмжлэгийг хүлээж байгаа нь сайшаалтай хэрэг юм. Монгол ба азийн бусад орнуудын хооронд эдийн засгийн байгууллагын төлөөлөгчид солилцож, худалдаа хийх, жижиг дунд үйлдвэр байгуулах, ажлын туршлага, мэргэжилтэн солилцох асуудлыг хэлэлцэн тохиролцож нилээд ажлууд хийгээд байна. Манай оронд тэдгээр улсуудын зарим хоршооллын шугамаар барилга байгууламжийн ажил эхлээд байна. Монгол, бусад орнуудын хамтарсан байгууллагууд байгуулагдаад амжилттай ажиллах эхлэлээ тавьсны дээр худалдааны үйл ажиллагаа итэвхижиж, зээл тусламж, хамтын ажиллагаа өргөжиж байна. Энэ харилцааг цаашид өргөжүүлэхээр Монгол ба зарим орнуудын хооронд эдийн засаг, ШУТ-ийн талаар хамтран ажиллах засгийн газрын хэлэлцээр /таван жилийн хугацаатай/ байгуулагдаж, түүнийг хэрэгжүүлэх хоёр талын төлөөлөгчдөөс бүрдсэн хамтарсан хороо байгуулагдан ажлаа явуулж эхлэв. Энэхүү хэлэлцээрээр хоёр орны хоорондын эдийн засаг, ШУТ-ийн хамтын ажиллагааг өргөтгөх цар хүрээг тэлэх боломжийг судлах программ боловсруулах, худалдааны харилцааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг харилцан дэмжих, байгалийн нөөцийг эрж хайх, олборлох, ашиглах, боловсруулах зэрэг маш өргөн хүрээтэй чухал асуудлуудыг хамарчээ.

Цаашдаа энэ харилцаа олон талын болох төлөвтэй. Ийм хамтын ажиллагаа нь манай орны хувьд эдийн засгийн одоогийн хүнд байдлаас гарч зах зээлийн системд идэвхитэй шилжихэд ч ихээхэн ач холбогдолтой.

Ер нь одоохондоо манайд шийдвэрлэгдээгүй байгаа бөгөөд цаашид Европ, Азийн зарим орнуудтай хамтран хиймээр томоохон ажлууд ч их байгаа юм. Тухайлбал, малын арьс шир, ноос ноолуур боловсруулах, шинэ техник, технологи нэвтрүүлэх, газрын баялгийг ашиглах, үйлдвэрийн техник, технологийг өөрчлөх, электрон тооцооны систем нэвтрүүлэх, мэргэжилтэй ажилчин, мэргэжилтэн бэлтгэх, зам харилцааг төгөлдөржүүлэх зэрэгт хамтран ажиллахад болох юм.

Азийн орнуудтай эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаагаа баттай тогтоож чадвал бид заавал хол орших бусад тивийн орноос их зардлаар бараа таваар авах гэх асуудал үгүй болно. Ер нь нэг тивийнхэн бүс нутгийнхаа амьдралын асуудлыг өөрсдөө шийдвэрлэх нь ашигтай ч байж болох юм. Тухайлбал: Азийн бүс нутгийн улсууд харилцан ашигтай, хамтран ажиллахад нутаг дэвсгэрийн ойр зэргэлдээ байршилт, хүн ардын зан заншил, амьдрал, ахуй, хэл яриа хүртэл ойролцоо тул цаашид хоршиж, түргэн хөгжих боломжоор илүү байдаг давуу талтай. Үүнийг дараах хэдэн нөхцөлөөр Монгол Улс, БНСУ-ын харилцаа, хамтын ажиллагааны жишээгээр тодорхойлж болох юм. Үүнд:

1. Монгол Солонгосын ард түмэн эрт дээр цагаас эхлэн эдийн засгийн талаар харилцан ашигтай хамтран ажиллаж байсан түүхтэй. Тухайлбал, XI зууны үед солонгосчууд монголд ирж уран барилга барих, анагаах эмчлэх, гар урлалын нарийн ажилд тусалж байсан бол монголчууд солонгост адуу мал бэлэглэх, мал маллах, арчлах, үржүүлэх арга ухаан эзэмшүүлэх зэргээр харилцан тусалж байсан уламжлалтай.

2. Ер нь зарим эрдэмтдийн томъёолдгоор бол буурай ба өндөр хөгжилтэй орнууд хоорондоо хамтран хоршиж ажиллахад “зохицолдоо” сайтай байдаг гэдэг. Харин хөгжлийн адил тэгш түвшинтэй хоёр орон бол хөрөнгө оруулалт хийх, техник, технологи, мэргэжилтэй ажиллах хүч солилцох хүрээ нь хомс байдаг талтай. Энэ томъёоллоор авч үзэхэд БНСУ эдийн засаг, ШУТ-ийн хөгжлийн өндөр түвшинд явж байгаа учир Монголд хөрөнгө оруулж техник, технологи нийлүүлэн оронд нь үйлдвэрийн түүхий эд буюу хамтын үйлдвэрийнхээ

бүтээгдэхүүнийг аваад, дэлхийн стандартын дээд зэргийн бүтээгдэхүүн болгож, хоёр орныхоо хэрэгцээг хангах ба экспортлоход манай хоёр орны аль алинд нь харилцан ашигтай байж болох юм.

3. Манай орны байгалийн баялагт Солонгосын аж үйлдвэрт түүхий эд болж чанарлаг бүтээгдэхүүн үйлдвэрлэж болохуйц бүрэн агуулга бүхий эрдэс ба минералын тохиромжтой түүхий эд ч нилээд байдаг. БНСУ-ын микроэлектроник, информатик, лазер, хими, нефть, эрчим хүч, цемент, автомашин, цахим ба цахилгаан техник, ган хайлуулах, нэхмэл сүлжмэл, биотехнологийн аж үйлдвэрүүдийн түүхий эдийн нилээд хэсгийг холоос өндөр үнээр импортлон авдаг нь үйлдвэрлэлийн үр ашигт нь таагүй нөлөөлдөг. Гэтэл эдгээр үйлдвэрүүдэд хэрэглэдэг түүхий эдийн нөөц нь бүс нутгийнх нь зэргэлдээ орших монголд элбэг байдаг нь Зүүн Хойд Азийн бүс нутгийн интеграцийн хүрээнд солонгос-Монголын хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд бүр ч илүү давуу боломжийг олгож байгаагаар тодорхойлогдоно.

Үүнтэй уялдуулан монголын ашигт малтмал болон минералын баялгийн нөөцийг сүүлийн 30-аад жилд судалсан геологийн эрэл хайгуулын дүнгээс товчхон танилцуулах нь бидний хүсэж байгаа хамтын ажиллагааны асуудлыг улам сонирхолтой болгох талтай.

Одоо манай оронд чулуун нүүрс, зэс, цагаан тугалга, алмаз, мөнгө, үнэт чулуу, хүдэр, вальфром, хайлуур жонш, фосфор, алт, мөнгө, үнэт чулуу, уран зэрэг 30 гаруй төрлийн ашигт ба эрдэс түүхий эдийн 500 гаруй орд, барилгын олон төрлийн материалыг илрүүлээд байна. Нефтийн орд ч олдож байна. Тэрчлэн чулуу нүүрсний 160 гаруй орд, шатах занарын 30 гаруй ордыг илрүүлээд байна. Зөвхөн нутгийн хойд ба дорнодын районд гэхэд л төмрийн хүдрийн 120 ордыг илрүүлээд байгаа юм. Ялангуяа зэс молибдений ордод асар их нөөц байгаа бөгөөд ганцхан Эрдэнэтийн овооны зэс молибдений нөөц гэхэд л нөөцөөрөө дэлхийд эхний аравт ордог ордын долоод орж байна.

Түүнчлэн ховор металлын ба полиметаллын ордуудыг илрүүлэн заримыг нь ашиглаж байна. Бас алтны ордууд олон аймаг сумдад байдаг. Хайлуур жонш нь монголын зүүн талын аймгуудад зонхилон тархсан нь бүр ч тааламжтай. Одоо Монголд 400 гаруй минералын халуун, хүйтэн рашаанууд

ажиллаж байгаа ба рашааных нь бүрэлдэхүүнд калий, натрий, кальций, магний, төмөр, азот, хүхэр, устөрөгч, хүчилтөрөгч болон маш ховор тохиолддог уран, радий, родон, литий, бром, ванадий зэрэг чухал элементүүд элбэг байдаг.

Мөн монгол нутагт малыг бэлчээрийн аргаар өсгөж мах, сүү, арьс шир, ноос ноолуурыг боловсруулан экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой бөгөөд одоо өвс ургамлынхаа дөнгөж 70%-ийг ашиглаж /хонинд шилжүүлснээр/ 56,3 сая мал адгуулж байгаа юм. Монгол нь эх газрын эрс тэс уур амьсгалтай учир өвс ургамал нь улирлаар солигдон байнга шинэчлэгддэгээс элдэв хорт нян үржихгүй, сайн чанарын тэжээл болдог онцлогтой. Энэ нь мал аж ахуйн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг олгодог.

4. Зүүн Хойд Азийн чөлөөт нээлттэй бүсийг монголын зүүн талд байгуулбал Монгол ба Зүүн Хойт Азийн орнуудын хамтын ажиллагаанд бүр ч сайн нөхцөл бүрдэх боломжтой болно. Эндээс төмөр замаар ачаа бараа тээж, БНХАУ-ын хойд районоор дайрч, усан замтай холбох бололцоотой ба тэгвэл Оросын алс дорнод, Япон, БНСУ, БНХАУ-ын хойд район ба Монголын зүүн районыг хамарсан худалдаа эдийн засгийн нээлттэй бүс буй болгох төсөл ч ойрын үед хэрэгжиж болох юм.

Энэ бол Зүүн Хойт Азийн бүс нутгийн хүрээн дэх зөвхөн Монголд байгаа худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны нөхцөл боломж, нөөц бололцоог харуулах үзүүлэлтүүд юм. Одоо бид энэхүү нөөц бололцоог зохистой ашиглахын тулд эдийн засгийн бүтэц, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлэхэд ШУТ-ийн дэвшил, эдийн засгийн гадаад бодлогыг чиглүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ зорилтыг амжилтай хэрэгжүүлэхэд Азийн орнууд тал бүрийн тусламж үзүүлж байгаа юм. Энэ мэтээр бусад орнуудад асар их нөөц, түүнийг ашиглах арвин их бололцоо байгаа нь тодорхой.

Луу хаашаа тэлэх вэ?

О.Ангараг

Хэдэн мянган жилийн түүхтэй “Торгон зам” Европын эдийн засгийг Хятадын эдийн засагтай холбож ирсэн гол худалдааны зам байсныг бүгд мэднэ. Дэлхий дахинаа чухаг хэрэгцээтэй цай, торго, шаазан зэрэг бүтээгдэхүүнийг олон зууны турш Хятадаас газрын болон усан замаар зөөж ирсэн